



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/173

Улаанбаатар хот

Тамхи худалдах зөвшөөрөл
сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14, 7 дугаар зүйлийн 7.9, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 14 дэх хэсэг, 8.2 дугаар зүйлийн 11.6 дахь хэсэг, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2011 оны 7/64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрнаас 500 метрийн тойргоос гадна байрлан, тамхи худалдах шаардлага ханган үйл ажиллагаа явуулж буй хавсралтад заасан нэр бүхий байгууллагын тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.

2.Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох худалдаа үйлчилгээний байгууллагын нэрийг хавсралтаар баталсугай.

3.Тамхины хяналтын тухай хуулийн холбогдох зүйл заалтыг мөрдөж ажиллахыг холбогдох аж ахуйн нэгжид, хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Цагдаагийн хэлтэс (Т.Лхагвасүрэн)-т, Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Ё.Гэрэлцэцэг)-т, 2 дугаар хорооны Засаг дарга (Б.Батзориг) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, зохион байгуулалт, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Дүүргийн менежер (Г.Дагвадорж)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

1225010690

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 02 сарын 18-ны өдрийн
А/173 захирамжийн хавсралт



ТАМХИ ХУДАЛДАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ

Д/д	Худалдаа үйлчилгээний байгууллагын нэр	Захирлын нэр	Хаяг, байршил	Харилцах утас
1.	Аз хур баялаг ХХК	Н.Энхсайхан	2 дугаар хороо Бор үзүүр 1-1 тоот	95862058